MNC
UBS Улаанбаатар телевиз
ntv NTV телевиз
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
Посольство Российской Федерации в Монголии
РЦНК Российский центр науки и культуры в Улан-Баторе
TUMED GROUP

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ОХУ-ын ЭСЯ, БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр Оросын шинжлэх ухаан соёлын төв (РЦНК)

РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА 2018

3 ДАХЬ УДААГИЙН

РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА

ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2018

03.15-17

ОРОСЫН БОЛОВСРОЛ - ДЭЛХИЙН БОЛОВСРОЛ

ОХУ-Д СУРАЛЦАХ ДАВУУ ТАЛУУД:

- Монголд хамгийн их тэтгэлэгт хөтөлбөртэй
- Монголд ойрхон
- Амьдралын өртөг хямд
- ОХУ бол дэлхийн соёл, шинжлэх ухааны төв

2018.03.15-17

Эрхэм хүндэт Монголын оюутан, сурагч, залуучууд аа!

Гурав дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа “Оросын боловсролын үзэсгэлэн-2018” арга хэмжээгээрээ дахин уулзахдаа бид баяртай байна.

Энэ жилийн үзэсгэлэнгийн гол онцлог бол 1990-ээд оноос хойш сүүлийн 25 жилийн хугацаанд анх удаагаа ОХУ-аас Монгол улсад бүх түвшний боловсрол олгох 500 хуваарь тэтгэлгээр олгож байгаа нь рекорд тогтоосон үзүүлэлт болж байна.

Мөн энэ удаагийн үзэсгэлэнд ОХУ-ын 16 муж, хотуудаас 30 гаруй их дээд сургуулиуд оролцож байгаа бөгөөд та бүхэн дэлхийн түвшний мэдлэг боловсролыг 100%-ийн тэтгэлгээр эзэмших нь алдаж болохгүй боломж юм.

Бид ОХУ-д тэтгэлгээр суралцах үүд хаалгыг өргөнөөр нээх үүднээс үзэсгэлэнгийн үеэр элсэлтийн бүртгэлийг явуулж, сонгон шалгаруулалтанд оролцох томоохон боломжийг олгож байна.

Орос орон бол дэлхийн хүчирхэг гүрэн. Оросын боловсрол, соёл, урлаг, яруу найраг, шинжлэх ухаан, техник технологийн нээлт дэлхийд тэргүүлдэг. Та бухэн ч мөн хөл нийлүүлэн алхаарай хэмээн хүсэж, сонгон шалгаруулалтандаа амжилттай оролцохыг хүсэн ерөөе!

Та бүхний сонголт мэргэн, ирээдүй тань гэгээлэг байх болтугай!

Е.Г.Михайлов

ОХУ-ын Монгол Улс дахь ЭСЯ-ны Зөвлөх,
Россотрудничество агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн,
Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал

DERZHAVIN TAMBOV STATE UNIVERSITY

Г.Р.ДЕРЖАВИНЫ НЭРЭМЖИТ ТАМБОВЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Г.Р.Державины нэрэмжит Тамбовын улсын их сургууль нь 1918 онд байгуулагдсан бөгөөд ОХУ-ын Төвийн хар шороот бүс нутгийн голлох дээд сургуулийн нэг юм. Тус их сургуульд 13000 оюутан, түүний дотор дэлхийн 64 орны 2400 орчим залуус суралцдаг. ТУИС-д дээд боловсрол олж авахыг сонирхсон залуусын сонирхол нь ирээдүйтэй олон сайхан мэргэжил, хөтөлбөрийн өргөн сонголтоор тодорхойлогддог.

Анагаах ухаан, экологи, нанотехнологи, мэдээллийн технологи, эдийн засаг, хэл судлал, когнитив хэл шинжлэл, менежмент зэрэг идэвхтэй хөгжиж байгаа салбаруудад 150 гаруй мэргэжлээр бакалавр, мэргэжилтэн, магистр, аспирантур, докторантур бэлтгэх сургалтыг явуулдаг. Мөн тус сургууль дээд сургуулийн өмнөх бэлтгэл сургалт, багтаасан сургалт, янз бүрийн дадлага, орос хэлний дамжаагаа санал болгож байна. Зарим төрлийн мэргэжлээр сургалтыг англи, франц хэл дээр явуулдаг.
Цаг агаарын таатай уур амьсгал, хотын сэтгэл татам байдал, хэрэглэгчдийн болон гадаад оюутнуудын дотуур байрны харьцангуй боломжийн өртөг зэрэг нь ТУИХ-д суралцах оюутан залуусыг татдаг юм.

Гадаадын олон

оюутан тус сургуулийн бэлтгэл ангид эхлэн суралцаж, орос хэлийг судлан, анагаах ухаан-биологийн, хүмүүнлэгийн болон эдийн засгийн чиглэлээр тодорхой бэлтгэлд сурдаг.

Олон жилийн турш тус их сургууль “Хэл судлал”-ын мэргэжлээр багтаасан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Сургалтын энэ хэлбэрээр хичээллэгч оюутнуудад зориулан хичээлийн тусгай төлөвлөгөө боловсруулсан ба үүгээр орос хэл, оросын уран зохиол, оросын соёлын талаар шинэ мэдлэгийг олж авах боломжтой байдаг.

Их сургууль нь гадаад оюутан залуусын бүтээлч чадварыг хөгжүүлэх их боломжтой байдаг бөгөөд Сургалтыг театр, хөгжмийн, дууны, найрал дууны, бүжгийн дугуйлан, спортын ордон “Антей”, фитнес-төв “Атлетико”, биеийн тамир-эрүүлжүүлэх цогцолбор, стадион, «Галдым» амралтын газар, Музей-үзэсгэлэнгийн цогцолбор, зооботаникийн цэцэрлэг, амьтны музей, геологийн музей тэдний өмнө нээлттэй байна.

Оюутнууд уран бүтээлийн уралдаан, спортын тэмцээнд идэвхтэй оролцдог. «ТУИС-ийн үндэстний соёлын Өдрүүд» олон улсын уламжлалт фестиваль хамгийн нэр хүндтэй уралдаан юм.

Энэ арга хэмжээний үеэр оюутан залуус дуулах, бүжиглэх, жүжиглэх, хоол хийх ур чадвараа үзүүлж, өөрийн эх орон, соёл, уламжлалынхаа талаар ярьж өгдөг.

Сургалтын чанар, боловсролын үйлчилгээний өртгийг ухаалгаар

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 392000, г.Тамбов, ул. Интернациональная 33, www.tsutmb.ru
тел.+ 7(4752) 72 -33- 04, e-mail: ums_tsu@mail.ru

ВЛАДИВОСТОКИЙН ЭДИЙН ЗАСАГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Владивостокийн улсын эдийн засаг, сервисийн их сургууль нь (ВУЭСИС) ОХУ-ын Алс Дорнодод байрладаг эдийн засгийн хүчирхэг их сургуулийн нэг юм. Тус сургууль эх орондоо болон гадаадад хэрэгцээ шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг төгсгөн гаргадаг.

Тус сургууль жилд нэг удаа загварын ертөнцийн томоохон дуулиантай арга хэмжээний гол төв болдог. Энд **Ази Номхон далайн бүс нутгийн орнуудын «PACIFIC STYLE WEEK» загвар болон гуа үзэмжийн индустрийн Долоо хоног зохиогддог**. Энэхүү арга хэмжээнд:

ВУЭСИС нь дорх чиглэлээр Алс Дорнодын их сургуулиудын дотор манлай сургууль юм:

- дизайн
- сервис ба аялал жуулчлал
- менежмент
- эдийн засаг

Тус их сургууль Владивосток хотын гол гол үйлдвэрийн газруудтай харилцаатай байдаг. Төгсөгчид ОХУ-ын янз бүрийн бүс нутгийн(Москва, Санкт-Петербург) болон гадаадын

(Япон, Хятад, Их британи, АНУ болон бусад орнууд) янз бүрийн компаниудад ажилладаг.

ВУЭСИС-д Узбекистан, Армени, Украин, Гүрж, Киргиз, Азербайджан, Хятад, Вьетнам, Өмнөд Солонгос, Лаос, Нигери, Конго, Афганистан, Энэтхэг зэрэг орнуудын **500 гаруй гадаад оюутнууд** суралцдаг.

Вячеслав Зайцев (ОХУ); Мисун Юм, дизайнер, Сангшин эмэгтэйчүүдийн их сургуулийн дизайн, загварчлалын тэнхимийн доцент(Өмнөд Солонгос); Фридерик Ли, дизайнер, Азийн загвар зохиогчдын холбооны гишүүн, 2010 оны Сингапурын залуучуудын олимпийн тоглолтын хувцас хариуцсан захирал (Сингапур) зэрэг цуутнууд оролцож байсан.

ВУЭСИС нь дэлхийн 13 орны 60 гаруй их сургуультай хамтран ажилладаг. Тус сургууль оросын болон гадаадын гэсэн **хоёр диплом олгодог мэргэжилтэн бэлтгэх** олон улсын төслүүд болон **солилцооны хөтөлбөрийг** хэрэгжүүлдэг.

ВУЭСИС нь ОХУ-ын Алс Дорнодод, Владивосток хотод байдаг.

Владивосток нь Япон тэнгисийн эрэг дээр байдаг порт-хот бөгөөд Ази-Номхон далайн бүс нутагт орох хаалга юм. Тус хот 1860 онд байгуулагдсан ба тус бүс нутгийн улс төр, соёл, эдийн засгийн төв юм(Дорнодын эдийн засгийн форум явуулдаг төв). Мөн Алс дорнодын бүс нутгийн шинжлэх ухаан-боловсролын томоохон төв.

Владивосток хот нь ОХУ-ын төв хэсэгтэй төмөр зам, авто зам, агаарын замаар холбогдсон. Мөн Япон, Өмнөд Солонгос, Хятад болон Ази-Номхон далайн бүс нутгийн бусад орнуудтай байнгын агаарын замаар холбогдож, Солонгос, Японийн порт хотуудтай гатлаг онгоцоор, Хятадын хил залгаа хотуудтай авто замаар тус тус холбогдсон.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Утас.: 8 (423)240-41-38
И-мэйл: international@vvsu.ru
Хаяг: Россия, г. Владивосток, ул. Гоголя 41

NATIONAL RESEARCH UNIVERSITY

ҮНДЭСНИЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИХ СУРГУУЛЬ «ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ»

Үндэсний эрдэм шинжилгээний их сургууль «Эдийн засгийн дээд сургууль» нь 1992 онд байгуулагдсан ОХУ-ын томоохон их сургууль юм.

274 жилийн дотор тус их сургууль нь тасралтгүй өсч хөгжин олон үзүүлэлтээрээ тэргүүлэх байр суурьт хүрчээ.

Олон улсын QS World University Rankings 2017-2018 чансаагаар Эдийн засгийн дээд сургууль нь дэлхийн 2500 гаруй шилдэг их сургуулийн дунд 392-р байрыг эзэлж, эдийн засаг, эдийн засгийн метрик, социолог судлал, бизнес, менежментийн үзүүлэлтээр оросын их сургуулийн дунд тэргүүлэх байрыг эзэлж байна.

Мөн хүмүүнлэгийн ухаан, математик, эрх зүй, олон улсын харилцаа, компьютерийн ухаанаар оросын шилдэг 5 сургуулийн нэг болсон. Мөн залуу их сургуулиудын дунд (50 нас хүртэл) тус сургууль нь дэлхийд 48 дахь шилдэг сургууль, ОХУ-д шилдэг нь болж байна.

Өнөөдөр Эдийн засгийн дээд сургуульд, түүний Москва, Санкт-Петербург, Доод Новгород, Пермийн салбар сургуулиудад 35000 гаруй оюутан, аспирант суралцаж байгаа ба бакалаврын 72 хөтөлбөр, магистрын 153 хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж байна.

Эдийн засгийн дээд сургууль нь Лондоны их сургууль, Лондоны эдийн засаг, улс төрийн ухааны сургууль, Сеулын Кен-хи их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, оюутнуудад давхар диплом авах ховорхон боломжийг олгож байна.

Тус сургууль магистрын давхар диплом олгох хөтөлбөрөөр 40 гаруй түнштэй хамтран ажиллаж байна. Боловсролын ийм хөтөлбөрөөр олж авсан боловсрол нь тус сургуулийн диплом болон түнш-их сургуулиудын дипломуудаар баталгаажраг. Энэ нь тус сургуулийг төгсөгчдийн мэргэжлийн өндөр чадварыг харуулж, хөдөлмөрийн зах зээл дээр өргөн их хэрэгцээ шаардлагтай байдгийг нь батаалгаажуулан өгч байдаг. Тус сургууль дэлхийн аль ч орны оюутан залууст нээлттэй ба өнөөдрийн байдлаар дэлхийн 76 орны 2000 гаруй оюутнууд энд сурч байна. Гадаад оюутнууд сонгосон мэргэжлийн дагуу орос хэл сурах бэлтгэл ангид сурч, бакалавр, магистрын англи хэл дээрх олон тооны хөтөлбөрийг сонгон суралцах боломжтой.

Эдийн засгийн дээд сургууль нь байгуулагдсан цагаасаа хойш 65000 мэргэжилтэнг үндсэн чиглэлүүдээр төгсгөн гаргасан. Тус сургуулийн диплом нь төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн зах зээл дээр хэрэгцээтэй байх баталгаа, оросын болон гадаадын нэртэй компаниудад хурдан өсөн дэвших баталгаа болж байдгийг туршлага харуулсан.

Жил бүр тус сургуулийн суурин дээр 500 гаруй суурь болон хавсрага шинжлэн судлах төсөл хэрэгжиж, 1000 гаруй социологийн судалгаа хийгдэж байна. Тус их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтнууд өндөр нэр хүндтэй олон улсын сэтгүүлүүдэд судалгааны өгүүллүүдээ нийтлүүлж байна. Мөн түүнчлэн 18000 гаруй тогтмол хэвлэлийн сэтгүүлүүд рүү орох боломжийг олгодогоороо Эдийн засгийн дээд сургуулийн номын сан нь оросын их дээд сургуулийн дунд хамгийн хосгүй номын санд тооцогддог юм.

ХОЛБОГДОХ ХАЯГ:
HSE International Admissions
Office 105, 13/4 Myasnitskaya str., Moscow 101000 Russian Federation
E-mail: inter@hse.ru / Tel: + 7 495 531 00 59
Website: https://www.hse.ru/en/

university
Industrial University of Tyumen

ТЮМЕНИЙ АЖ ҮЙЛДВЭРИЙН ИХ СУРГУУЛЬ

Тюмений аж үйлдвэрийн их сургууль нь ОХУ-ын шинжлэх ухаан-боловсрол, их сургуулиудын томоохон цогцолборуудын нэг бөгөөд түлш-эрчим хүчний болон эдийн засгийн бусад салбарт мэргэжилтэн бэлтгэдэг Уралаас Номхон далайн хүртэлх цорын ганц их сургууль юм. Тус сургуульд 30000 гаруй оюутан суралцдагаас 1500 гаруй нь дэлхийн 38 орноос ирсэн гадаад оюутнууд юм. Тус их сургуулийн бүрэлдэхүүнд Тюмений 7 дээд сургууль(Геолог, нефть хий олборлох дээд сургууль, Барилгын дээд сургууль, Аж үйлдвэрийн технологи, инжинирингийн дээд сургууль, Тээврийн дээд сургууль, Сервис үйлчилгээ, салбарын удирдлагын дээд сургууль, Архитектор, дизайны дээд сургууль, Нэмэлт болон зайн боловсролын дээд сургууль), Олон мэргэжилт коллеж, лицей сургууль орохоос гадна аспирантур, докторантурын сургалт явагддаг. Бэлтгэх чиглэлийн хүрээ их өргөн: нефть хий, геологи, машин үйлдвэрлэл, химийн технологи, техносферийн аюулгүй байдал, тээврийн үйл явц, мэдээлэл зүй, эдийн засаг, менежмент, уран барилга, барилга болон нийт 47 чиглэлээр бакалавр, 57 чиглэлээр магистр бэлтгэдэг. Оюутны хэрэгцээнд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий сургалтын лаборатори, янз бүрийн мэдээллийн хэрэгсэл бүхий танхим, эрдэм шинжилгээ, уран бүтээлийн болон спортын клуб, секцүүд, орчин үеийн дотуур байр, гуанз, кафе, спортын танхим, номын сан-мэдээллийн төв, уншлагын танхим, сувилал, хотоос гадна байдаг сувилал, сургалт-бэлтгэлийн бааз ажилладаг. Хичээлийн байр нь хотын төвд, дотуур байрнаас хэдхэн алхмын зайд байдаг.

Тус их сургуулийг төгсөгчид ПАО «Газпром», ПАО «Газпром-нефть», ОАО «Сургутнефтегаз», ПАО «НК Роснефть», ПАО «ЛУКОЙЛ», ПАО «Транснефть», «Halliburton International», ПАО «СИБУР», «KCA Deutag Drilling» болон бусад нэртэй компаниудад ажилладаг.

ХОЛБОГДОХ ХАЯГ:
Россия
625000, г. Тюмень, ул. Володарского, 38
Тел.: +7 (3452) 28-36-65, +7 (3452) 68-34-05
e-mail: orsio@tyuiu.ru
www.tyuiu.ru

Уральский федеральный университет

УРАЛЫН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ(УРХИС)

УРАЛЫН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ(УрХИС) нь 100 жилийн түүхтэй ба ОХУ-ын томоохон их сургуулийн нэг юм. Тус их сургууль нь суурь боловсрол болон орчин үеийн асуудлыг шийдэх инновац хандлагыг өөртөө багтаасан их сургууль юм.

УрХИС нь ОХУ-ын ТОР-3 хотын нэг бөгөөд аж үйлдвэрийн томоохон төв болох Екатеринбург хотод байдаг. Тус хот нь худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын бизнес, соёл, цэнгээнт амралтын дэд бүтэц хөгжсөн ОХУ-ын эрчимтэй хөгжиж байгаа хотын нэг юм.

УРХИС-ИЙН ЧАНСАА

- TOP-10: 2013 оноос хойш ОХУ-ын шилдэг их дээд сургуулиудын "5-100" төслийн гол оролцогч;
- TOP-60: Европ, Төв Азийн хөгжиж байгаа орнуудын шилдэг их сургуулиуд;
- TOP-500 World QS University-ны чансаанд;
- TOP 251-300 QS WU-ын чансаанд математикийн чиглэлээр;
- TOP-400 QS-ын чансаанд: физик, астрономи, электротехник, электроникийн чиглэлээр;
- БРИКС-ийн их сургуулиудын дунд 78-р байр (Дэлхийн их сургуулиудын QS чансаа: BRICS-ийн орнууд)

УРХИС ТОО БАРИМТААР

Уралын холбооны их сургууль нь цогцолбор их сургууль бөгөөд байгаль, техник, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, эдийн засгийн салбарт бакалавр, магистр, аспирантур, докторантурын 400 орчим хөтөлбөр хэрэгжиж байна.

УрХИС-д дэлхийн 86 орны 35000 гаруй оюутан суралцаж, 4000 гаруй багш ажиллаж байна. Тус сургуулийн олон улсын 12 лабораторт баруун нэртэй их сургуулиудын эрдэмтэд ажилладаг.

Өнөөдөр УрХИС-д гадаадын 2300 гаруй оюутан залуус суралцаж байгаа бөгөөд тэдэнд зориулсан 2 тохилог дотуур байр ашиглалтанд орсон. УрХИС-ыг 360 000 гаруй хүн төгссөн.

ХОЛБОГДОХ ХАЯГ:
620002, Россия, г. Екатеринбург,
ул. Мира, 19
Тел. +7 (343) 375-46-27
Сайт: www.urfu.ru
Эл.почта: admission@urfu.ru

ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2018

М. В. ЛОМОНОСОВЫН НЭРЭМЖИТ ХОЛБООНЫ ХОЙД(АРКТИКИЙН) ИХ СУРГУУЛЬ

СЕВЕРНЫЙ (АРКТИЧЕСКИЙ) ФЕДЕРАЛЬНЫЙ УНИВЕРСИТЕТ ИМЕНИ М. В. ЛОМОНОСОВА

М. В. Ломоносовын нэрэмжит холбооны Хойд(Арктикийн) их сургууль нь (г. Архангельск, Россия, www.narfu.ru) ОХУ-ын Баруун хойд бүсийн шинжлэх ухаан-боловсролын томоохон төв бөгөөд Евроазийн их сургуулиудын холбоо, Оросын тэргүүлэх их сургуулиудын холбоонд ордог.

Өнөөдөр тус их сургуулийн 7 дээд сургуульд 20000 гаруй оюутан, түүний дотор ТУХН, Европ, Ази, Африк, Хойд болон Өмнөд Америкийг оролцуулсан дэлхийн 55 орноос ирсэн 700 гаруй гадаад оюутан суралцдаг.

Шинжлэх ухаан-боловсролын үйл ажиллагааг 28 хичээлийн корпус, эрдэм шинжилгээний төхөөрөмжийг хамт олноороо ашиглах хэт орчин үеийн 2 төв, 18 шинжлэх ухаан-боловсрол, инновац-технологийн төв, 25 том лаборатори, шинжлэх ухааны номын сангийн суурин дээр хэрэгжүүлдэг.

Тус сургуулийг төгсөгчид барилга, нефть хий олборлох, эрчим хүч, мэдээллийн технологийн салбарт мега-төслүүд хэрэгжүүлдэг оросын болон гадаадын том том компаниудад хэрэгцээ шаардлагатай байдаг.

Сургууль нь байгалын болон техникийн чиглэлийн зэрэгцээ хэл шинжлэл, соёл хоорондын харилцаа, сэтгүүл зүй, хууль, олон улсын харилцаа, сэтгэл судлал, багш арга зүй зэрэг хүмүүнлэгийн салбарт мэргэжилтэн бэлтгэх академик уламжлалтай.

Холбооны Хойд их сургууль нь дэлхийн 100 гару их сургууль, байгууллагатай амжилттай хамтран ажиллаж байгаа олон улсын их сургууль юм. Тус сургуулийн 400 гаруй оюутан жил бүр Норвеги, Канад, АНУ, Финлянди, Швед, Франц, Германы түнш их сургуулиудад солилцооны болон боловсролын олон улсын хөтөлбөрт оролцон суралцаж, гадаадын компаниудын тэтгэлэгт дэмжлэгийг авч, инновац үзэл санааны олон улсын хөтөлбөр, уралдаанд оролцож байна.

Боловсрол, шинжлэх ухаан, сургалтын гадуурх үйл ажиллагаанд оюутан залуус авьяас чадвараа хөгжүүлэх олон боломж оюутнуудын өмнө нээлттэй байдаг. Оюутнуудын санаачлагыг дэмжих, бүтээлч хүчин чадлыг хөгжүүлэх зорилгоор сургуулийн бааз суурин дээр сургуулий уран бүтээлийн төв, сайн дурынхны төв, орчин үеийн судалгааны төв, оюутны өөрийн удирдлагын төв тус тус ажилладаг.

Тус сургуулийн нийгмийн хөтөлбөр нь оюутны амьдралыг яруу тод, эрч хүчтэй болгоход чиглэгдсэн. Дэд бүтэц нь 12 дотуур байр, спортын клуб, усан бассейн, цаны стадион зэргийг нэгтгэдэг.

Гадаадын элсэн суралцагсадад тус сургуульд элсэн орох өргөн боломж, ОХУ-ын БШУЯ-ны квотын хүрээнд тэтгэлгээр суралцах боломж ч хүртэл бий. Гадаадад амьдардаг орос иргэд оросын элсэн суралцагсдтай ижил эрхтэйгээр уралдаант шалгалтын хүрээнд төсвөөр суралцах боломжтой.

Тус сургууль элсэн оргсдод боловсролын өргөн үйлчилгээг үзүүлэхэд таатай байна:

- техник, байгалын ухаан, нийгэм-хүмүүнлэгийн чиглэлээр бакалавр, магистр, аспирантурт суралцах 360 гаруй хөтөлбөр;
- боловсролын олон улсын хамтарсан хөтөлбөр;
- англи хэл дээрх хөтөлбөр, дамжаа
- гадаадын түнш их сургуулиуд дээр хийх богино хугацааны даадлага.

Суралцагсад тус сургуулийн бэлтгэл ангийн суурин дээр их сургуулийн өмнөх бэлтгэлд суралцах, орос хэл сурах, сонирхсон хөтөлбөрөөрөө суурь бэлтгэл хийх боломжтой юм.

Бид элсэхийг хүсэгчдэд сонирхсон асуултынх дагуу зөвөлгөө өгөхөд баяртай байгаа болно :

ХОЛБОГДОХ ХАЯГ:
Управление международного сотрудничества САФУ
Адрес: Россия, г. Архангельск, набережная Северной Двины, д. 17, офис 1326а
Сайт: www.narfu.ru / E-mail: international@narfu.ru
Телефон: +7 (8182) 216 196

УРАЛЫН УЛСЫН ХУУЛИЙН ИХ СУРГУУЛЬ

Уралын улсын хуулийн их сургууль нь (цаашид – УрУХИС гэх) 1918 онд байгуулагдсан цагаасаа эхлэн 100 жилийн турш оросын болон гадаадын ажил олгогчдод хуулийн өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж байна.

Ажил олгогчид манай сургуулийг өндөр үнэлдэг. Тус сургууль ОХУ-ын улсын удирдах элит төлөөллийн боловсрологоор их дээд сургуулийн чансаанд 2014 онд 3-р байрыг

О.Е. Кутафины нэрэмжит Москвагийн улсын хуулийн академи, ОХУ-ын ГХЯ-ны Олон улсын харилцаан дээд сургуультай хуваан эзэлсэн.

Манай сургуулийн бүрэлдэхүүнд Прокурорын дээд сургууль, Хууль зүйн дээд сургууль, Төрийн болон олон улсын эрх зүйн дээд сургууль, Эрх зүй, хөдөлмөр эрхэлтийн дээд сургууль, Эчнээ, түргэвчилсэн сургалтын дээд сургууль гэсэн 5 дээд сургууль, нэмэлт боловсролын факультет, 24 тэнхим ордог. Сургууль «Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн хангамж" мэргэжлээр бакалавр, мэргэжилтний хөтөлбөр, магистрын 20 хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж байна.

УрУХИС олон улсын түвшин рүү чиглэсэн ба мэдээллийн технологи, орос улсын болон олон улсын боловсролын стандартад суурилдаг. Манай сургууль хуулийн салбарын боловсон хүчин бэлтгэх талаар гадаадын олон их дээд сургуультай үр бүтээлтэй хамтран ажиллаж байна. Төгсөгчдийн 95% нь ажил хөдөлмөр эрхэлдэг ба хууль хамгааллын байгууллага, шүүх, өмгөөлөл, нотариат, төрийн болон орон нутгийн эрх барих байгууллага, банк, даатгал, хөрөнгө оруулалтын салбар, үйлдвэрийн газар, өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад амжилттай ажиллаж байна.

Манай сургууль олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ба багш, оюутнууд жил бүр бага хурал, чуулга-уулзалт, уралдаан тэмцээн, семинар зэрэг олон улсын арга хэмжээнүүдэд оролцдогоос гадна сургууль маань өөрөө олон улсын иймэрхүү арга хэмжээний талбар болдог.

УрУХИС гадаадын олон их дээд сургуультай хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Бид өвөрмөцөөр сэтгэдэг, нийтэч, харилцаа сайтай, амжилтанд тэмүүлдэг, бие даасан сонголт хийж чаддаг, их ажиллаж, хариуцлагыг өөртөө авч чаддаг тийм хүмүүст дуртай.

Өдрийн сургалтын 1 семестрийн өртөг 1184 ам.доллар, өдөр-эчнээ сургалтын 1 семестрийн өртөг 629 ам.доллар, эчнээ сургалтын 1 семестрийн өртөг 502 ам.доллар байдаг болно.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Сектор по приему абитуриентов
Адрес: 620137, г. Екатеринбург, ул. Комсомольская, д. 21, каб. 109
Телефон: (343)374-40-33),
Email: pk@usla.ru / Сайт: http://www.usla.ru/

ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2018

RUDN university

ОРОСЫН УЛС ТҮМНИЙ НАЙРАМДЛЫН ИХ СУРГУУЛЬ (РУДН)

5100 RUSSIAN ACADEMIC EXCELLENCE PROJECT

Оросын улс түмний найрамдлын их сургууль (РУДН) нь 1960 онд ЗХУ-ын Засгийн газрын тусгай тогтоолоор “Патрис Лумумбын нэрэмжит улс түмний найрамдлын их сургууль” нэртэйгээр байгуулагдсан ба одоо болтол гадаадын иргэдийг маш олон мэргэжлээр бэлтгэдэг оросын гол их сургуулийн нэг юм. Тус сургуулийн 100000 төгсөгчид дэлхийн бараг бүх орнуудад ажиллаж байна. Улс түмний найрамдлын их сургуульд 6 факультет, 10 дээд сургууль 1 академи, 156 эрдэм шинжилгээ-боловсролын лаборатори, хамтран ашиглах 4 төв ажиллаж байна.

Тус сургуульд дорх факультет/дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэдэг:

- Аграр-технологийн дээд сургууль;
- Хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны факультет;
- Инженерийн академи;
- Анагаах ухааны дээд сургууль;
- Хэл судлалын факультет;
- Физик-математик, байгалын ухааны факультет;
- Экологийн факультет;
- Зочид буудлын бизнес, аялал жуулчлалын дээд сургууль;
- Орос хэл, ерөнхий боловсролын хичээлийн факультет;
- Гадаад хэлний дээд сургууль;
- Дэлхийн эдийн засаг, бизнесийн дээд сургууль;
- Биохимийн технологи, нанотехнологийн дээд сургууль;
- Гравитаци, космологийн сургалт-эрдэм шинжилгээний дээд сургууль;
- Харьцуулах боловсролын бодлогын сургалт-эрдэм-шинжилгээний дээд сургууль;
- Эдийн засгийн факультет.
- Хуулийн дээд сургууль.

Нийт оюутны тоо 31766, тэдгээрээс 8295 нь дэлхийн 155 орноос ирсэн гадаад оюутнууд.

Москва хотын захиргаа Улс түмний найрамдлын их сургуулийн оюутны хотхоныг москвагийн их сургуулиудын шилдгээр шалгаруулсан ба тус сургууль «Оюутны шилдэг дотуур байрны төлөө» бүх оросын уралдаанд түрүүлсэн. Оюутны 14 дотуур байр үндсэн хичээлийн байрнаас холгүй байдаг. Ойн бүсийн ойролцоох 50 гектар талбайд спортын цогцолбор, стадион, концертны зал, эмнэлэг номын сан, үндэстэн үндэстний 30 гаруй кафе, дэлгүүр ажилладаг.

РУДН-ийн нутаг дэвсгэр дээр хотын поликлиник, мэргэжлийн эмнэлгийн тусламж үзүүлдэг олон мэргэжлийн эмчилгээ-урьдчилан сэргийлэх газар байдаг.

2000 видеокамер 24 цагийн ажиглалт хийдэг. Хичээлийн бүх байр, оюутны дотуур байранд нэвтрэх хяналтын цахим системтэй. Гал түймрийн автомат дохиоллын систем ажилладаг. Сургууль өөрийн цагдаагийн хэсэгтэй.

Сургуульд Интернациональ соёлын төв (Интерклуб) ажилладаг ба тэнд хичээлийн чөлөө цагаар 30 ансамбль, дугуйлангийн аль нэгэнд хүслээрээ хичээллэж болно. 150 орчим оюутны нэгдэл, түүний дотор монгол оюутны нутгийн зөвлөл ажилладаг.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

117198, Москва, ул. Миклухо-Маклая, д. 6
Тел.: +7 (495) 787-38-03, доб. 17-84 / E-mail: http://www.rudn.ru

САНКТ-ПЕТЕРБУРГИЙН УУЛЫН ИХ СУРГУУЛЬ

Тус их сургууль нь Екатерина II хатан хааны зарлигаар 1773 онд байгуулагдсан оросын анхны техникийн дээд сургууль.

Уулын их сургууль ОХУ-ын ард түмнүүдийн соёлын үнэт өвийн статустай бөгөөд оросын үндэсний судалгаа-шинжилгээний их сургуулийн тоонд ордог.

Уулын их сургууль дэлхийд нэртэй олон эрдэмтдийг төрүүлэн гаргасан юм

Академич А.П. Карпинский, Е.С Федоров, В.А. Обручев, Н.С. Курнаков, Н.Г. Келль, Д.В. Наливкин, И.М. Губкин, А.П. Герман, А.А. Скочинский нарын нэр дэлхийд алдартай.

Төгсөгчдийн дунд улс орнуудын төрийн тэргүүн нар ч бий. Энэ нь ОХУ-ын Ерөнхийлөгч Путин В.В., Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, Таджикистан Улсын анхны Ерөнхийлөгч Махкамов К.М. нар юм.

7 марта 2018 оны 3 сарын 7-нд Париж хотноо Санкт-Петербургийн уулын их сургуулийн бааз суурин

Их британий чансаа тодорхойлох QS World University Rankings агентлагийн дүнгээр уулын их сургууль "Инженерийн ухаан-ашигт малтмалын олборлолт ба уул уурхайн аж үйлдвэр" чиглэлээр 15-р байр эзэлж, дэлхийн инженер-техникийн шилдэг ТОП-50 их сургуулийн тоонд(2017.03.08) орлоо.

дээр уулын техникийн боловсролын салбар дахь Олон улсын төгөлдөрших Төвийг ЮНЕСКО-гийн ивээл дор байгуулах гэрээнд гарын үсэг зурав.

Уулын музей нь дэлхийн 80 гаруй орны 240 000 орчим хосгүй үзмэртэй бөгөөд байгаль-шинжлэх ухааны чиглэлээр дэлхийн шилдэг 3 музейн тоонд ордог. Шинжлэх ухаан-техникийн баялаг номын сан нь XV – XIX зууны 1,2 сая гаруй ном сэтгүүлтэй ба орчин үеийн компьютерийн техник, цахим каталогоор тоноглогдсон.

Уулын их сургууль Санкт-Петербург хотын түүхэн төвд оршдог. Энд мөн хичээлийн корпус, тохилог дотуур байрууд байдаг.

Өнөөдөр тус сургуульд дэлхийн 60 гаруй орноос ирсэн 8000 орчим оюутан суралцдаг.

«Архитектура», «Барилга», « Ховор барилга байгууламжийг барих», «Хавсрага геодези», «Хавсрага геологи», «Геологи хайгуулын технологи», «Уул уурхай», «Экологи», «Мэдээлэл зүй ба тооцоолон бодох техник», «Дулааны эрчим хүч ба дулааны техник», «Цахилгаан эрчим хүч ба цахилгаан техник», «Машин үйлдвэрлэл», «Технологийн машин тоног төхөөрөмж», «Технологийн процесс, үйлдвэрлэлийн автоматжуулалт», «Химийн технологи», «Техно-сферийн аюулгүй байдал», «Нефть хий», «Газар зохион байгуулалт, кадастры», «Металлур-гия», «Тээврийн процессийн технологи», «Эдийн засаг», «Менежмент» болон бусад чиглэлүүдээр мэргэжилтэн бэлтгэдэг.

Төсвөөр суралцагч бүх оюутнууд формын хувцас үнэгүй хэрэглэдэг. Уулын их сургууль нь спортын хоёр цогцолбор, бассейн, эрүүлжүүлэх баазтай. Дотуур байр бүр гуанз, тренажер зал, угаалгын газартай.

ХОЛБОГДОХ ХАЯГ:
Гадаад оюутнуудтай ажиллах деканатын газар:
тел.: +7 (812) 328-82-55.
Уулын их сургуулийн сайт
www.spmi.ru
Эл. почта: foreign@spmi.ru

3 ДАХЬ УДААГИЙН ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2018
РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА

БУРИАДЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

1. БУРИАДЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ нь Буриад Улсын цорын ганц сонгодог их сургууль юм! Тус сургууль 7 факультет, 6 дээд сургуультай. Коллеж нь боловсрол, шинжлэх ухаан, удирдлага, эдийн засаг, эрүүл мэнд, нийгмийн салбарын байгууллагуудын боловсон хүчин бэлтгэдэг болохоор систем үүсгэдэг сургууль юм.

2. БУИС- ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын сургалт-эрдэм шинжилгээний гол төвийн нэг! Тус сургууль ОХУ-ын сургалт-эрдэм шинжилгээний гол төвүүд болох Москва, Новосибирск, Иркутск, Томск болон гадаадын их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудтай шинжлэх ухаан, соёл, боловсролын салбарт хамтран ажилладаг.

3. БУИС нь оюутан багш нарын өнөр нөхөрсөг гэр бүл юм. БУИС бол орчин үеийн компьютерийн технологи. Сургуулийн номын сангийн фонд нь 1,2 сая гаруй номтой. Номын сангийн бүрэлдэхүүнд улсын төв номын сангийн диссертацийн номын сан болон WebofScience, E-library, E-biblioteka ресурс руу орох бүрэн текст оролттой цахим уншлагын танхим ажилладаг.

4. БУИС өнөөдөр бүс нутагтаа суурь шинжлэх ухааны манлай их сургууль. Эрдэм шинжилгээ- судалгааны ажилд оролцох оюутны идэвхтэй оролцоо нь олж авсан мэдлэгээ практик дээр амжилттай хэрэглэх үндэс болж, судалгаа хийх дадал, хамт олон дор ажиллах чадварыг хөгжүүлдэг. Олон улсын болон бүх оросын бага хурал, уралдаан тэмцээн, олимпиадуудаас авсан тэргүүн, шагналт байрууд нь үүний нотолгоо юм.

5. БУИС нь орчин үеийн, тохилог оюутны хотхон бөгөөд орчин үеийн шинэ шинэ дотуур байр, хоорондын харилцаа, олон тооны наадам, уралдаан! Энэ бол оюутны болон бүтээлч амьдралын жинхэнэ уур амьсгал!

6. БУИС бол олон улсын өргөн харилцаа. Манай оюутнууд гадаадын их дээд сургуулиуд дээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн практик дадлагыг хийх боломжтой байдаг.

7. БУИС нь бие бялдрын хувьд төгс болох боломж. Сургуулийн уламжлал нь Европ, дэлхийн томоохон тэмцээнүүд дээр үзүүлдэг буриадын тамирчдын амжилт, хүчирхэг суурин дээр суурилсан байдаг. БУИС-ийн тамирчид хот, их дээд сургууль хоорондын, муж, бүс нутгийн, бүх оросын болон олон улсын тэмцээнүүдэд байнга амжилттай оролцдог ба тэргүүн, шагналт байруудыг тогтмол эзэлдэг!

8. БУИС нь өөрийн бүтээлч хүч чадлыг нээх боломж. БУИС-д оюутан залуус бүрийн бүтээлч авьяас чадварыг нээж хөгжүүлэх бүх нөхцөл бүрдсэн байдгаас гадны уран бүтээлийн байнгын хамтлаг, хамт олон ажилладаг. Харилцах, бүтээн туурвихад дутагдах зүйл байхгүй!

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Элсэлтийн комисс: Тел. 8(3012) 21-74-26 , ул.Смолина, 24а, 0105 каб., Эл.адрес: udp@bsu.ru

Олон улсын харилцааны хэлтэс: Тел.8 (3012) 21-18-64, ул.Смолина, 24а, 0203 каб., Эл.адрес: intdep@bsu.ru

ITMO UNIVERSITY

САНКТ-ПЕТЕРБУРГИЙН ҮНДЭСНИЙ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЕХАНИК, ОПТИКИЙН ИХ СУРГУУЛЬ

Санкт-Петербургийн үндэсний судалгаа шинжилгээний мэдээллийн технологи, механик, оптикийн их сургууль

ИТМО их сургууль нь ОХУ-ын соёл, шинжлэх ухаан, боловсрол, инновацийн хосгүй төв болох Санкт-Петербург хотод байдаг. 1900 оны 3 сарын 26-нд байгуулагдсан.

* Оросын мэдээллийн болон фотоникийн технологийн салбарын тэргүүлэх их сургууль. 2009 онд үндэсний судалгаа шинжилгээний их сургуулийн статустай болсон. THE чансаагаар оросын тэргүүлэх гурван их сургуулийн нэг.

* ИТМО их сургууль нь дэлхийн IT их сургуулиудын шилдэг 100-д ордог, ComputerScience-ийн салбарт THE чансаагаар 76-р байр эзэлдэг, инженерийн ухаанаар дэлхий ТОП -400 их сургуулийн тоонд орсон, физикийн ухаан салбарт QS чансааны ТОП-400-д дэвшсэн.

* ACM ICPC програмчлалын олон улсын оюутны багийн тэмцээн дэлхийд 7 удаа түрүүлсэн цорын ганц их сургууль, мөн Google Code Jam, Facebook Hacker Cup и Яндекс. Алгоритм програмчлалын олон улсын бусад тэмцээний ялагч их сургууль.

* Тус сургуулийн төгсөгчид ANDROID-ын албан ёсны хэл KOTLIN—г зохиосон.

*Инновацын хосгүй бүтэцтэй: 2 бизнес-инкубатор, Технопарк, Оюун санаа, арга зүй, практикийн нэлттэй лаборатори, урлан — лаборатория



ФабЛаб.

2016 онд ИТМО их сургууль ЮНЕСКО-гийн "Их сургуулийн хосгүй орчин":шинжлэх ухаан-боловсрол-инноваци" медалийг хүртсэн.

Тус сургууль нь сонгодог бус их сургууль. Бидний зорилго бол хувь хүнийг өв тэгш, өрсөлдөх чадвартай хүн болгон хөгжүүлэх боломжийг нээж өгөх, даяаршлын зорилтуудыг шийдвэрлэхэд зоригжуулах явдал юм.

Боловсролын үйл явцад инновац байдлаар хандах хандлага тус сургуульд байгаа ба бүх хөтөлбөр чиглэл чиглэлээр хуваагдан ангилагдсан. 5 мега чиглэл-5 шинжлэх ухааны тренд бий:

Компьютерийн технологи, удирдлагын мегафакультет (киберфизик систем, робототехник, мэдээллийн болон кибер аюулгүй байдал)

Фотоникийн мегафакультет (оптикийн технологи ба лазерын систем, квантын харилцаа ба шинэ функциональ материал)

Мэдээлэл дамжуулах технологийн мегафакультет (хиймэл оюуны технологи, өндөр бүтээмжит тооцоолол)

Биотехнологийн болон нам температурын системийн мегафакультет (биотехнологи, хөргөх технологи, хүнсний инновац бүтээгдэхүүн, хүрээлэн байгаа орчныг хамгаалах)

Технологийн менежмент, инновацийн факультет (эдийн засаг, менежмент, маркетинг, технологийн инновацийн удирдлага).

Шинжлэх ухааны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл: IT, фотоника, робототехника, квантын харилцаа, дамжуулах аааанагаах ухаан, хотын хөгжил судлал, Art&Science, ScienceCommunication.

Гадаад оюутнуудад зориулсан хөгжингүй дэд бүтэц, судалгаа шинжилгээ явуулах шинжлэх ухаан суурь, англи хэл дээрх 16 боловсролын хөтөлбөр, оюутнуудыг дасгах, интеграцлах хөтөлбөр, дэлхийн их дээд сургуулиудтай байгуулсан түншийн харилцаа, Оросын хамгийн сайхан, европын хотод сурч амьдрах боломж, сонгодог бус уур амьсгалд умбаж соёлын арга хэмжээ, сургуулиас зохион байгуулдаг ер бусын төслүүдэд оролцох боломжууд бий.

Сургуулийн албан ёсны сайт: www.ifmo.ru

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Элсэх асуудлаар:
Гадаад оюутныг сургах төв
Захирал: Серова Марина,
тел.: +7 (812) 314-77-75
E-mail:int.students@corp.ifmo.ru

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хамтран ажиллах асуудлаар:
Олон улсын хамтын ажиллагааны газар
Дарга: Ким Ирина,
тел.: +7(812) 315-28-41
E-mail:kim@mail.ifmo.ru

Г.В.ПЛЕХАНОВЫН НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

Г. В. ПЛЕХАНОВЫ НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА!

Г.В. Плехановын нэрэмжит ОЭЗИС-ийн Улаанбаатар дахь салбар сургууль 1999 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн ба 18 жилийн туршид эдийн засаг, санхүүгийн салбарт өндөр мэргэжилтэй мэргэжилтнүүдийг төгсгөн гаргаж байна.

Тус сургуульд чанартай дээд боловсрол олж авах бүх нөхцөл бүрдсэн: оросын холбооны стандарт боловсролын хөтөлбөртэй,

хичээлийн танхимууд орчин үеийн техник тоноглолтой, оюутан бүрт ганцаарчлан хандах боломжтой, найрсаг хамт олон, оюутны гайхалтай амьдралтай.

Профессор-багш нарын бүрэлдэхүүн – оросын болон гадаадын эрдэм шинжилгээний нэртэй сэтгүүлүүдэд өгүүлэл материал нийтлүүлж, сурах бичиг, гарын авлаг зохиосон өндөр мэргэжлийн мэргэжилтэн багш нар. Олон багш мэргэжлээрээ консалтингийн болон судалгаан шинжилгээний төслүүдэд оролцдог практик туршлагатай бөгөөд оюутнуудынхаа эрдэм шинжилгээний төсөл, өгүүлэл, нийтлэлүүдийн эрдэм шинжилгээний удирдагч нь болдог.

Бакалавр бэлтгэх чиглэл **«Эдийн засаг», мэргэжил «Санхүү, зээл», 4 жил**	**Элсэн суралцах нөхцөл:** Анхны дээд боловсрол олж авах Монгол Улсын иргэд элсэлтийн шалгалт өгч орно: • Математик (мэргэжлийн); • Орос хэл; • Англи хэл

БИДНИЙ ДАВУУ ТАЛ

- Улаанбаатар хотод суралцаад Москвад байх төв сургуулийнхаа дипломыг илүү бага өртгөөр авна;
- Ихэнх хичээлийг Москвагаас ирсэн багш нар заадаг;
- Солилцоогоор төв сургуульдаа суралцах боломжтой;
- Нэгдүгээр курсийн оюутнууд квартир маягийн дотуур байранд үнэ төлбөргүй амьдрана;
- Оюутны сонирхол дүүрэн амьдрал: КВН, спортын уралдаан тэмцээн, соёл, эрдэм шинжилгээний арга хэмжээнүүд;
- Шилдэг оюутнуудад олгодог стипенд

ХОЛБОГДОХ ХАЯГ:
Адрес: 210351, Монгол Улс, Улаанбаатар, Энх тайвны өргөн чөлөө 131
E-mail: ulan-bator.pk@rea.ru / Веб-сайт: www.ulanbator.rea.ru
Тел: +976-99-91-11-68 (Viber, WhatsApp);
8-10-976-11-45-05-96; 8-10-976-11-45-06-79

Б.Б. ГОРОДОВИКОВЫН НЭРЭМЖИТ ХАЛИМАГИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

